



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/51

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "А" заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хилийн боомтуудын экспорт, импортын үйл ажиллагаанд хяналт тавих, хорио цээрийн хяналт шалгалт, хууль, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах үйлсэд хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч Т.Золзаяа, Г.Энхцэцэг нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Т.Золзаяа, Г.Энхцэцэг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчулуун/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ